



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/З/11

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 11/01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3-т тусгагдсан Есөнзүйл сумын тохижилт, бүтээн байгуулалтын зардалд 50,000,000 (тавин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг Есөнзүйл сумын Засаг дарга (Т.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0665

D:My Doc. Zahiramj. Zasag darga